



ТӨВ АЙМАГ  
ЖАРГАЛАНТ СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2020 оны 04 сарын 02 өдөр

Дугаар 20

Жаргалант сум

Цэргийн албыг дүйцүүлэн хаах иргэний  
нэрсийн жагсаалт батлах тухай

Сумын Засаг дарга Т.Цолмонгэрэлийн өргөн мэдүүлсэн “Цэргийн албыг дүйцүүлэн хаах иргэдийн нэрсийн жагсаалт”-ыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцээд “Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай” хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалт, “Цэргийн албаны тухай” хуулийн 30 дугаар зүйл, Монгол улсын Засгийн газрын 2008 оны 49 дүгээр тогтоолоор батлагдсан “Цэргийн албыг дүйцүүлэн хаах журам”-ын 20 дугаар зүйлийн “а” заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Цэргийн албыг дүйцүүлэн хаах иргэдийн нэрсийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.
2. Сумын Засаг дарга /Т.Цолмонгэрэл/-д ДААЛГАХ нь:
  - 2.1. Цэргийн албыг дүйцүүлэн хааж байгаа иргэний сургалт, дайчилгаа, өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах
  - 2.2 Цэргийн албыг дүйцүүлэн хааж байгаа иргэний үүрэг гүйцэтгэх үеийн аюулгүй байдлыг хангуулах арга хэмжээ авах
  - 2.3 Шаардлагатай тохиолдолд цэргийн албыг дүйцүүлэн хааж байгаа иргэнд оногдуулсан үүрэг гүйцэтгэх үед нь ажлын хувцас, багаж хэрэгслээр хангах арга хэмжээ авах
  - 2.4 Цэргийн албыг дүйцүүлэн хаах хугацаандаа хүндэтгэн үзэхээс бусад шалтгаанаар сургалт, цугларалт, дайчилгааг тасалсан, үүргээ биелүүлэхээс татгалзсан, сахилга хариуцлага алдсан, түүнчлэн гэмт хэрэг үйлдсэн иргэнийг уг албанаас хасах тухай саналыг аймгийн Засаг даргад тавьж шийдвэрлүүлэх
  - 2.5 Цэргийн албыг дүйцүүлэн хаах хугацаа дууссан иргэнийг уг албанаас хасах тухай саналыг аймгийн Засаг даргад хүргүүлэх
3. Цэргийн албыг дүйцүүлэн хаах хугацаанд томилгоот үүргээ биелүүлэх мэдлэг чадварыг бүрэн эзэмшин, оногдуулсан үүрэгтэй холбоотой ажлуудыг хариуцлагатайгаар гүйцэтгэхийг цэргийн албыг дүйцүүлэн хааж буй хавсралтаар батлагдсан нэр бүхий иргэдэд даалгасугай.

4. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга /П.Ганпүрэв/-т үүрэг болгосугай.

ДАРГА



Д.УРАНЧИМЭГ

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн 2020 оны  
04 дүгээр сарын 02-ны өдрийн 20 дугаар тогтоолын хавсралт



ЦЭРГИЙН АЛБЫГ БИЕЭР ДҮЙЦҮҮЛЭН  
ХААХ ИРГЭНИЙ НЭРСИЙН ЖАГСААЛТ

№	Овог нэр	Регистрийн дугаар	Багийн харьяалал	Утасны дугаар
1	Ч.Ган-Очир	ИТ97091712	Өгөөмөр 2-р баг	89763303
2	Б.Цолмон	НМ00240511	Буурал 1-р баг	89529097
3	О.Баасанболд	НМ98081915	Буурал 1-р баг	88323777
4	Ө.Аринуболор	НМ98110633	Буурал 1-р баг	88406949
5	Б.Чүлтэм	НМ97061413	Буурал 1-р баг	88375535

\*\*\*\*\*